

## **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БАЙДЛЫН ТАЙЛАН**

### **4.1. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал:**

\* Аймгийн Засаг даргын дэргэд Олон нийттэй харилцах албыг шинээр ажиллуулж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган аймгийн бодлого шийдвэр, цаг үеийн мэдээллийг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, иргэдийн санал хүсэлтийг бодлого, шийдвэрт тусгах ажлууд хийгдэж байна.

\* Аймгийн ЗДТГ-ын [www.dornogobi.gov.mn](http://www.dornogobi.gov.mn) цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт, үйл ажиллагааны стратегийн зорилт, төрийн албан хаагчдын танилцуулга, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам зэргийг байрлуулсан.

Мөн хуульд заасан үүргээ хэрэгжүүлэх ажил үйлчилгээний чиглэлээ иргэд олон нийтэд ил тод байлгах зорилгоор албан тасалгааны хаягийн дэргэд ажил хариуцсан албан тушаалтны нэр, ажлын байрны зорилт, хийгдэх ажлуудыг тодорхой бичиж байрлуулсан. Байгууллагын үүдний танхимд ажилтнуудын зураг, нэр, албан тушаал, гүйцэтгэж буй ажил үүрэг, холбоо барих утас зэрэг мэдээллийг мэдээллийн самбарыг шинэчлэн байрлуулсан.

\* Аймгийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвд Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн үйлчилгээ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хадгаламж банк, аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдтэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн гэсэн нийт 8-н төрлийн үйлчилгээг иргэдэд үзүүлж байна. Тус төв 2010 онд 55587 иргэнд үйлчилгээ үзүүлээд байна.

\* Төрийн албаны дадлага туршлагатай ахмадууд болон эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын 2009 оны 183 дугаар захирамжаар байгуулж, үйл ажиллагааны журмыг баталлаа. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг боловсруулах, тулгамдсан асуудлыг оновчтой шийдвэрлэхэд аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх явдал орон тооны бус зөвлөлийн үндсэн үүрэг байх юм.

\* Аймгийн ЗДТГазарт Эрх зүйн туслалцааны төв ажиллаж иргэдэд хууль эрх зүйн мэдээ, мэдээлэл лавлагаа, зөвлөгөөг өгч зарим иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэн ажиллаж байна. Мөн Хууль зүйн хэлтсээс УИХ-аас батлан гаргасан хууль, тогтоомж, тэдгээрийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулж байна. .

Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг жилдээ 2-3 удаа салбар салбараар нь зохион байгуулж иргэдэд байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлахын зэрэгцээ хүссэн мэдээ, мэдээлэл өгч зохих үйлчилгээг үзүүлэн ажиллаа.

### **4.2. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал:**

\* ЗДТГ-ын хамт олныг байгууллагын соёл, зохион байгуулалтын хүрээнд Нийгмийн асуудал хариуцсан ажлын хэсэг, Мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан ажлын хэсэг, Биеийн тамир, спортын асуудал хариуцсан ажлын хэсэг, Урлаг, соёл хариуцсан ажлын хэсгүүдээр зохион байгуулж төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, идэвхи санаачлагыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан нь үр дүнд хүрч байна.

\* Өргөн, Замын-Үүд, Хатанбулаг, Мандах, Даланжаргалан, Сайншанд сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Өргөн, Айраг, Даланжаргалан, Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Саран хөхөө театрын дарга, Даланжаргалан сумын Соёлын төвийн даргын ажлын байр зэрэг удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг нийтэд зарлан 62 иргэн хамрагдсанаас 49 иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдэж тэднээс 13 иргэн томилогдон ажиллаж байна.

\* Төрийн жинхэнэ албан тушаалд 2010 онд шинээр ажилтан элсүүлж авах захиалгыг аймгийн хэмжээнд нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлэн 19 ажлын байр зарлагдсан байна. Ажлын байрны зарыг төрийн албаны зөвлөл болон аймгийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон нутгийн FM радио, телевизээр зарлаж нийтэд мэдээлсэн. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтанд тухайн ажлын байрны шаардлагад нийцсэн 164 хүн бүртгүүлэн шалгалт өгснөөс дэс түшмэлийн ангилалд 45, туслах түшмэлийн ангилалд 61 иргэн тэнцсэн байна.

#### **4.3. Төсөв, санхүүгийн ил тод байдал:**

Монгол Улсын Засгийн газраас баталсан аймгийн 2011 оны төсвийн орлого, зарлагын мэдээлэл нь Монгол Улсын төсвийн ил тод байдлын [/www.iltod.gov.mn/](http://www.iltod.gov.mn/) цахим хуудаст тавигдсан.

Аймгийн 2011 оны орон нутгийн төсвийг 2010 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ҮИ хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан төсвийн талаарх мэдээллийг МҮОНТ-ийн Монголын мэдээ хөтөлбөрийн туузан мэдээгээр болон орон нутгийн телевизүүдээр олон нийтэд мэдээлсэн.

Аймгийн 2010 оны эхний хагас жилийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн [Dornogobi.gov.mn](http://Dornogobi.gov.mn) цахим хуудсанд байрлуулж, олон нийтэд мэдээлсэн. Мөн аймгийн 2010 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбар болон Нэг цонхны үйлчилгээний цэг дэх мэдээллийн самбарт байрлуулж иргэд, олон нийтэд мэдээлсэн.

Төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээллийн самбарт аймгийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга, төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг сар бүр гаргаж хэвшсэн.

#### **4.4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал:**

\* Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2010 онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний жилийн эцсийн тайланд тусгагдсан нийт 22 бараа, ажлууд /50 сая төгрөгнөөс дээш ажил, 30-сая төгрөгнөөс дээш бараа/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээлттэйгээр □Зууны мэдээ□ болон □Өдрийн сонин□, Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд нийтэлж, үр дүнг тухай бүрт нь мэдээлж байна.

\* Улсын төсвийн 2031,6 сая төгрөг, орон нутгийн төсвийн 1057,8 сая төгрөг, байгууллагын урсгал төсөвт тусгагдсан 197,7 сая, нийт 3287,1 сая төгрөгийн батлагдсан хөрөнгөөр 2010 онд нийт 41 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороог байгуулан, бүрэлдэхүүнд нь төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

\* 2010 оны 3 дугаар сард Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв ТББ-ын сургагч багшийг аймагтаа урьж ирүүлэн бүх сумд, агентлаг төсөвт байгууллагын 50 албан хаагчдыг сургалтанд хамруулан 28 албан хаагч худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан болж, сертификат аваад байна.

\* Хуулийн дагуу нээлттэй зарласан тендерт оролцож, шалгарсан болон шалгараагүй компаниудын талаарх мэдээллийг Засгийн газрын веб сайтад тавьж, тендер шалгаруулалтын талаарх ил тод байдлыг хангаж ажилласан. 2010 онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний улирал бүрийн тайланг тухай бүр байгууллагын цахим хуудсанд байршуулж байлаа.

/Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлын дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргав/

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ

/Монгол улсын Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолын биелэлт/

Д/д	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилтийн тухай тэмдэглэл	Биелэлт /Хувь/
<b>Нэг. Үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал</b>			
	<p>Дараахь зүйлсийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тогтмол шинэчилж байх:</p> <ul style="list-style-type: none"> <li>* байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;</li> <li>* албан хаагчийн ёс зүйн дүрэм;</li> <li>* төрийн үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн овог, нэр, албан тушаал, хариуцсан ажил, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарь;</li> <li>* төрийн үйлчилгээ авахтай холбоотой материалын жагсаалт;</li> <li>* байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, заавар</li> </ul>	<p>Аймгийн Засаг даргын дэргэд Олон нийттэй харилцах албыг шинээр ажиллуулж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг ханган аймгийн бодлого шийдвэр, цаг үеийн мэдээллийг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж, иргэдийн санал хүсэлтийг бодлого, шийдвэрт тусгах ажлууд хийгдэж байна.</p> <p>Аймгийн ЗДТГ-ын <a href="http://www.dornogobi.gov.mn">www.dornogobi.gov.mn</a> цахим хуудас болон байгууллагын мэдээллийн самбарт, үйл ажиллагааны стратегийн зорилт, төрийн албан хаагчдын танилцуулга, байгууллагын үйл ажиллагаанд дагаж мөрдөх журам зэргийг байрлуулсан.</p> <p>Мөн хуульд заасан үүргээ хэрэгжүүлэх ажил үйлчилгээний чиглэлээ иргэд олон нийтэд ил тод байлгах зорилгоор албан тасалгааны хаягийг ойлгомжтой хаяглаж ажил хариуцсан албан тушаалтны нэр, ажлын байрны зорилт, хийгдэх ажлуудыг тодорхой бичиж байршуулсан. Байгууллагын хүлээн авах үүдний танхимд ажилтнуудын зураг, нэр, албан тушаал, гүйцэтгэж буй ажил үүрэг, холбоо барих утас зэрэг мэдээллийг агуулсан мэдээллийн самбарыг байршуулсан.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 10 дугаар албан даалгаварын заалтуудыг удирдлага болгон байгууллага бүр өөр дээрээ мэдээллийн булан, иргэдийн санал авах хайрцаг ажиллуулж, ажилтнуудын ажлын байрны үндсэн чиг үүргийг ил тод бичиж байрлуулсан</p> <p>Аймгийн хэмжээний төрийн байгууллагуудад дагаж мөрдөх Төрийн захиргааны албан хаагчийн ёс зүйн дүрмийг аймгийн Засаг даргын 2010 оны А/408 дугаар захирамжаар шинэчлэн баталлаа. Ёс зүйн дүрмийг 14 сумд болон нийт төрийн албан хаагчид сурталчилж, ил тод байрлууллаа.</p>	100%

1.2	Тухайн байгууллагаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;	<p>Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газраас иргэдэд үйлчлэх ажлыг ил тод, шуурхай байлгах, шат дамжлагыг багасгах, иргэдийг чирэгдүүлж, хүнд суртлыг дагуулдаг аливаа илэрлийг таслан зогсоох, төрийн үйлчилгээний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар илүү анхаарч байна. Үүнний нэг илрэл нь Төрийн захиргааны бүх шатны байгууллагын түвшинд “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэх ажлыг зохион байгуулж, эрчимжүүлэх, төрийн үйлчилгээг ил тод, шуурхай хүргэн, хүнд суртал, авилгын эсрэг тэмцлийг хүчтэй болгох зорилгоор “Нэг цонхны үйлчилгээ”-г нэвтрүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2007 оны 03, 264 дүгээр тогтоол, Ерөнхий сайдын 2007 оны 1 тоот захиргааны тушаалын дагуу төсөл хэрэгжүүлэгч байгууллага Хүний аюулгүй байдлын судалгааны төв, Швейцарийн хөгжлийн агентлагтай хамтарч аймгийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийг 2009 оны 07 дугаар сарын 15-ны өдөр нээж, үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Аймгийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвд иргэдэд үзүүлэх үйлчилгээний талаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж Аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Татварын хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтсийн иргэний бүртгэлийн үйлчилгээ, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Хадгаламж банк, аймгийн Засаг даргын Тамгын газрын иргэдтэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн гэсэн нийт 8-н төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэж ажиллаж байна. Уг үйлчилгээг хүргэх төрийн албан хаагчид нь тухайн салбартаа мэргэшсэн, энэ чиглэлээр ажлын туршлагатай, харилцааны өндөр соёлтой зэргийг нь харгалзан 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.</p> <p>Аймгийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний төв нь 2010 оны жилийн эцсийн байдлаар 55587 иргэнд үйлчилгээ үзүүлээд байна.</p>	100%
1.3	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хуулиар хориглоогүй аливаа мэдээллийг	Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дэргэд Эрх зүйн туслалцааны төв ажиллаж иргэдэд хууль эрх зүйн хүссэн мэдээ,	100%

	<p>иргэдэд үнэ төлбөргүй, хүндрэл чирэгдэлгүй өгөх зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>мэдээлэл лавлагаа, зөвлөгөөг өгч зарим иргэдэд эрх зүйн туслалцаа үзүүлж, төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөллийн үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэн ажиллаж байна.</p> <p>УИХ-ын үйл ажиллагааг сурталчлах төв нь УИХ-аас батлан гаргасан хууль, тогтоомж, тэдгээрийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгууллаа.</p> <p>Төрийн байгууллагуудын нээлттэй хаалганы өдөрлөгийг жилдээ 2-3 удаа салбар салбараар нь зохион байгуулж иргэдэд байгууллагуудын үйл ажиллагааг сурталчлахын зэрэгцээ хүссэн мэдээ, мэдээлэл өгч зохих үйлчилгээг үзүүлэн ажиллаа.</p> <p>Төрийн байгууллагуудаас иргэдэд хүссэн мэдээ, мэдээлэл, лавлагаа, зөвлөгөөг өөрсдийн ажлын чиг үүргийн дагуу өгч байгаа байна.</p> <p>Дорноговь аймгийн <a href="http://www.dornogobi.gov.mn">www.dornogobi.gov.mn</a> вэбсайтыг тогтмол ажиллуулж төр захиргааны шийдвэр болон мэдээ, мэдээллийг иргэдэд тогтмол шинэчлэн хүргэж ажиллаж байна.</p>	
1.4	<p>Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрээ тухай бүр Хууль зүй, дотоод хэргийн ямаар хянуулан, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;</p>	<p>Засгийн газрын 2009 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан журмын хүрээнд захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гэж юуг хэлэх, цаашид хэрхэн хянуулах тухай арга зүйн зөвлөмжийг нийт сумдын ЗДТГ-ын дарга нарт танилцуулж журмыг хяналтанд авч ажиллалаа.</p> <p>Аймгийн Засаг даргаас захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр буюу дүрэм журам баталсан захирамжийг батлан гаргахдаа тус журамд заасан зохих үе шатыг дамжин хянагдаж гарч байна. Шийдвэрийн төслийг тухайн асуудалд холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн саналыг харгалзаж үзэхээс гадна аймгийн ЗДТГ-ын бүх хэлтсүүд хянаж зохих санал, зөвшөөрлийг өгч ажиллаж байна.</p> <p>2010 онд аймгийн Засаг даргаас нийт 535 захирамж батлагдан гарсанаас 90 хувьд нь хууль зүйн хэлтсээс эрх зүйн үндэслэлтэй эсэхэд хяналт тавьж санал, зөвшөөрөл олгож ажилласан байна. Мөн 2010 онд хэм хэмжээ тогтоосон нийт 17 захирамж гарсан байна. Үүнээс нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлэхээр гаргасан захиргааны хэм хэмжээ тогтоосон 1 захирамжийг ХЗДХ-ийн яаманд хүргүүлж бүртгүүлсэн.</p> <p>Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг гаргах</p>	100%

		<p>үе шатыг зохих журмын дагуу хэрэгжүүлэн төслийг Дорноговь аймгийн вэбсайтад болон байгууллагын дотоод сүлжээнд байршуулах, төслийг эрх ашигтай нь холбогдох бүлгүүдэд түлхүү танилцуулан хэлэлцүүлэг хийж саналыг нь аах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.</p>	
1.5	<p>Төрийн бодлогын баримт бичиг болон нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авч, үндэслэлтэй гэж үзвэл төсөлд тусгадаг байх;</p>	<p>Төрийн бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг боловсруулахдаа Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу уг шийдвэрийн нөлөөллийн шинжилгээг хийж, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд, мэргэжлийн шинжээч, эрдэмтдийн саналыг авч хэлэлцүүлэг зохион байгуулах, иргэдийн саналыг авч боломжтой эсэхийг судлан тусгах арга хэмжээг авахыг нийт албан тушаалтнуудад үүрэгжүүлж ажиллаж байна.</p> <p>Төрийн албаны дадлага туршлагатай ахмадууд болон эрдэмтэн судлаачдаас бүрдсэн орон тооны бус зөвлөлийг 21 хүний бүрэлдэхүүнтэйгээр аймгийн Засаг даргын 2009 оны 183 дугаар захирамжаар байгуулж, үйл ажиллагааны журмыг баталлаа. Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогыг боловсруулах, тулгамдсан асуудлыг оновчтой шийдвэрлэхэд аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт зөвлөгөө дэмжлэг үзүүлэх явдал орон тооны бус зөвлөлийн үндсэн үүрэг байх юм.</p>	100%
1.6	<p>Санал, хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл хүлээн авах утас буюу хайрцаг /дэвтэр/ ажиллуулан, түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх;</p>	<p>Аймгийн Засаг даргын 2009 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 426 тоот захирамжаар Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг телефон утсаар хүлээж авах журмыг батлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Иргэдийн санал, хүсэлт, гомдол, мэдээллийг авах утас нь аймгийн Засаг даргын Тамгын газрын “Иргэдийг хүлээн авах байр”-ны 23913 тоот утас, аймгийн “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийн утас 23597 тоот утсаар ажлын цагт хүлээн авахаар журамласан. Мөн Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2009 оны 106 тоот тушаалаар аймгийн ЗДТГ-ын хэлтэс, албан хаагчдын “Нээлттэй утас”-н дээр ажиллах өдөр, цагийн хууваарь, санал, хүсэлт, гомдол, мэдээллийг бүртгэх дэвтэрийн загварыг баталсан. Аймгийн SBS телевиз, FM 107.5 радиогоор “Нээлттэй утас”-ны талаар сурталчилгаа хийлгэж ард иргэдэд</p>	100%

		<p>хүргэж байна. Мөн агентлагийн дарга, сумдын Засаг дарга нарт уг журмыг хүргүүлж, сурталчлах ажлыг дор бүрдээ зохион байгуулахыг үүрэг болгосон. Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 10 дугаар албан даалгаварыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд төрийн байгууллага бүр өөр дээрээ мэдээллийн булан ажиллуулж, иргэдийн санал авах хайрцгийг байнга байрлуулж, ажилтнуудын ажлын байрны үндсэн чиг үүргийг ил тод бичиж байрлуулан ажиллаж байна.</p>	
1.7	<p>Өргөдөл, гомдлыг хуульд заасан хугацаанд шийдвэрлэж, хариуг өгч хэвшсэн байх.</p>	<p>Дорноговь аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг “Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд хандан гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” Монгол улсын хууль, Хуулийн хэрэгжилтийг зохион байгуулахтай холбогдсон зарим арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 67 дугаар тогтоол, Аймгийн ЗДТГ-т ирсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг хянан шийдвэрлэх тухай журам зэрэг эрх зүйн хүрээнд шийдвэрлэж ирлээ.</p> <p>2010 оны жилийн эцсийн байдлаар иргэдээс нутгийн захиргааны байгууллагад хандан 6975 өргөдөл, гомдол ирүүлснийг судлан үзэж 6952 өргөдлийг зохих журмын дагуу шийдвэрлэж хариу өгсөн бөгөөд шийдвэрлэх хуулийн хугацаа болоогүй 23-н өргөдөл судлагдаж байна.</p> <p>Иргэд санал хүсэлтээ хүссэн үедээ, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангах үүднээс «Иргэдийн санал хүсэлт хүлээн авах» байрыг 2.5 сая төгрөгийн хөрөнгөөр шинэчлэн засварласан Аймгийн ЗДТГ-ын Иргэдтэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн иргэдийн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч удирдлагад мэдээлэн тухай бүр шийдвэрлүүлж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд “Иргэдийн хүлээн авах байр”-аар 150 гаруй иргэн ирж өргөдөл гомдол, санал хүсэлтээ тавин холбогдох хариуг авсан.</p> <p>Аймгийн Засаг дарга 7 хоног бүрийн «Даваа, Баасан» гаригийг иргэдийг хүлээн авах өдөр болгосонтой холбогдуулан 2010 оны жилийн эцсийн байдлаар 100 гаруй иргэнийг хүлээн авч санал хүсэлтийг сонсож зохих хариуг өглөө.</p> <p>Аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт хандаж</p>	100%



		2010 оны жилийн эцсийн байдлаар 117 өргөдөл ирсний 114 өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэсэн бөгөөд судлагдах шатандаа явагдаж байгаа 3 өргөдөл байна.	
<b>Хоёр. Хүний нөөцийн бодлогын ил тод байдал</b>			
2.1	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журам боловсруулан хэрэгжүүлсэн байх;	<p>Аймгийн Засаг даргын захирамжаар 2009 онд батлагдсан стратеги төлөвлөгөөнд аймгийн хэмжээний хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулж, хянах асуудал тусгагдсан.</p> <p>Мөн 2010 онд Төрийн албан хаагчийн стандартыг төлөвшүүлэх хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд “Төрийн албан хаагчийн стандарт”-ыг өөрийн байгууллагадаа боловсруулан мөрдөж байна.</p>	100%
2.2	Байгууллагын хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах арга замыг хүний нөөцийн стратегид тусгасан байх;	<p>Хүний нөөцийн удирдлагын ил тод, нээлттэй байдлыг хангах талаар стратеги төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Байгууллагад шинээр орох албан хаагчдад байгууллагын дотоод журам, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулж, зөвшөөрсөн тохиолдолд ажлын байраар хангах, сул ажлын байрыг нийтэд зарлан сонгон шалгаруулах, төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэлтэй иргэдээс нөхөх замаар сонгон шалгаруулж ажлын байраар хангаж байна.</p> <p>Төсвийн ерөнхий менежерүүдийг манлайлах ур чадварыг дээшлүүлэх талаар анхаарч Төрийн захиргааны манлайлалыг дээшлүүлэх чиглэлээр Төрийн албаны зөвлөлөөс Шведийн төслөөр 3 сургагч багшийг сургаж төгсгөсний дагуу энэ ажлын хүрээнд 3 удаагийн сургалтаар 60 гаруй 40 ерөнхий менежерийг манлайлалын шаталсан сургалтанд хамруулж мэдлэг чадварыг дээшлүүлсэн байна.</p>	100%
2.3	Хүний нөөцийн стратегийн хэрэгжилтийг үнэлэх, шинэчлэх үйл ажиллагаанд албан хаагчдын оролцох боломжийг бүрдүүлсэн байх	Аймгийн Засаг даргын захирамжаар 2009 онд батлагдсан стратеги төлөвлөгөөнд аймгийн хэмжээний хүний нөөцийн бодлогыг тодорхойлохдоо хэрэгжилтийг үнэлэх боломжийг бүрдүүлсэн.	100%
2.4	Байгууллагын соёл, зохион байгуулалт, үйл ажиллагааны нээлттэй байдлын талаархи сэтгэл ханамжийн судалгааг албан хаагчдаас жил бүр авч, дүнг ил тод танилцуулан, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээ авсан байх;	ЗДТГ-ын хамт о ньг байгууллагын соёл, зохион байгуулалтын хүрээнд Нийгмийн асуудал хариуцсан ажлын хэсэг, Мэдээлэл, сургалт сурталчилгаа хариуцсан ажлын хэсэг, Биеийн тамир, спортын асуудал хариуцсан ажлын хэсэг, Урлаг, соёл хариуцсан ажлын хэсгүүдээр зохион байгуулж төрийн	100%

		<p>албан хаагчдын үйл ажиллагаа, идэвхи санаачлагыг дээшлүүлэхэд анхаарч ажилласан нь үр дүнд хүрч байна.</p> <p>Мөн Төрийн албаны зөвлөлийн 2007 оны 48 дугаар тогтоолоор баталсан „Төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин /үр дүнгийн гэрээний биелэлт/-г үнэлэх журам,,-ын дагуу ажилтан бүр байгууллагын үйл ажиллагааны талаар сэтгэл ханамжийн тэмдэглэгээ хийдэг.</p>	
2.5	Сул орон тооны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарласан байх;	<p>2010 онд Өргөн, Замын-Үүд, Хатанбулаг, Мандах, Даланжаргалан, Сайншанд сумдын ИТХ-ын нарийн бичгийн дарга, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга, Өргөн, Айраг, Даланжаргалан, Улаанбадрах сумын Засаг даргын Тамгын газрын дарга, Саран хөхөө театрын дарга, Даланжаргалан сумын Соёлын төвийн даргын ажлын байрны сонгон шалгаруулалтыг нийтэд зарлан 62 иргэн хамрагдснаас 49 иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдэж тэднээс 13 иргэн томилогдон ажиллаж байна.</p> <p>Төрийн жинхэнэ албан тушаалд 2010 онд шинээр ажилтан элсүүлж авах захиалгыг аймгийн хэмжээнд нэгтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. 2010 оны 06 сард 19 ажлын байр зарлагдсан байна. Ажлын байрны зарыг төрийн албаны зөвлөл болон аймгийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон нутгийн FM радио, телевизээр зарласан. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад орох иргэдийг Ажлын байрны шаардлагад нийцсэн 164 хүн бүртгүүлэн шалгалт өгснөөс дэс түшмэлийн ангилалд 45, туслах түшмэлийн ангилалд 61 иргэн тэнцсэн байна.</p>	100%
2.6	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр байгууллагын дотоод журамд өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг зохион байгуулсан байх.	<p>Төрийн албан хаагчийн үр дүнг хагас, бүтэн жилээр дүгнэн тэдэнд байгууллагын дотоод журамд заасны дагуу урамшуулал олгох арга хэмжээг авч ажиллаж байна.</p>	100%
<b>Гурав. Төсөв, санхүүгийн ил тод байдал</b>			
3.1	Төсвийн төслийг боловсруулахдаа байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэргүүлэх чиглэлтэй нягт уялдуулсан байх;	<p>Аймгийн 2011 оны орон нутгийн төсвийн төслийг Монгол Улсын Засгийн газраас баримталж буй бодлого чиглэл болон аймгийн Засаг даргын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх</p>	100%

		үндсэн чиглэлтэй уялдуулан боловсруулж, 2010 оны 12 дугаар сарын 26-ны өдөр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ҮІ хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан.	
3.2	Үндэсний аюулгүй байдал болон төрийн нууцтай холбоотойгоос бусад байгууллагын тухайн жилийн төсөв, урьд оны төсвийн гүйцэтгэл, дараа оны төсвийн төслийг Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байх:	<p>Монгол Улсын Засгийн газраас баталсан аймгийн 2011 оны төсвийн орлого, зарлагын хязгаар Монгол Улсын төсвийн ил тод байдал /www.iltod.gov.mn/ цахим хуудаст тавигдсан.</p> <p>Аймгийн 2011 оны орон нутгийн төсвийг 2010 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын ҮІ хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, батлагдсан төсвийн талаарх мэдээллийг МҮОНТ-ийн Монголын мэдээ хөтөлбөрийн туузан мэдээгээр болон орон нутгийн телевизүүдээр олон нийтэд мэдээлсэн.</p>	100%
3.3	Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх;	<p>Аймгийн 2010 оны эхний хагас жилийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг аймгийн Dornogobi.gov.mn цахим хуудсанд байрлуулж, олон нийтэд мэдээлсэн. Мөн аймгийн 2010 оны эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбар болон Нэг цонхны үйлчилгээний цэг дэх мэдээллийн самбарт байрлуулж иргэд, олон нийтэд мэдээлсэн.</p> <p>Сумдын Засаг дарга, Засаг даргын орлогч, Багийн Засаг дарга нар болон бусад ажил хариуцсан мэргэжилтнүүдийг хамруулан зохион байгуулагдсан нэгдсэн сургалт, семинарт аймгийн төсвийн гүйцэтгэлийн явцын талаар мэдээ, мэдээлэл тогтмол хийж ажиллав.</p> <p>Төсвийн ил тод байдлыг хангах зорилгоор аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээллийн самбарт аймгийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга, төрийн сангийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг сар бүр гаргаж хэвшсэн.</p> <p>Аймгийн Засаг даргын тамгын газраас орон нутгийн радио, телевизийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан, орон нутгийн радио телевизээр ард иргэдэд аймгийн Засаг дарга, түүний ажлын албаны ажлын тайлан, аймгийн төсөв санхүүгийн мэдээллийг тогтмол хүргэж ажиллав.</p>	100%
3.4	Байгууллагын санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь	Аймгийн 2009 оны жилийн эцсийн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийгдсэн аудитын тайлан,	100%

	байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн байх;	зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн мэдээллийн самбар болон аймгийн Нэг цонхны үйлчилгээний мэдээллийн самбарт байрлуулж олон нийтэд мэдээлсэн. Аймгийн 2010 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийгдсэний дараа аудитын тайлан, зөвлөмжийг аймгийн <a href="http://www.Dornogovi.gov.mn">www.Dornogovi.gov.mn</a> цахим хуудсанд тавихаар төлөвлөж байна.	
3.5	Тухайн жилийн батлагдсан төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулсан тохиолдолд энэ тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангасан байх;	Аймгийн 2010 оны орон нутгийн төсвийн нэмэлт өөрчлөлтийг <a href="http://Dornogobi.gov.mn">Dornogobi.gov.mn</a> цахим хуудсанд байрлуулсан.	100%
3.6	Зөвхөн хууль тогтоомжид заасан төлбөр, хураамжийг үйлчлүүлэгчээс авч, түүний хэмжээний тухай цахим хуудсаар болон бусад хэлбэрээр олон нийтэд мэдээлсэн байх;	Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан орон нутгийн төсвийн орлогод орох татвар төлбөр, хураамж, бусад орлогоор 2010 онд орон нутгийн төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр 8767,9 сая төгрөг оруулж, төлөвлөгөөг 110,2 хувь биелүүлсэн. Аймгийн 2009 онд болон 2010 оны эхний хагас жилд орон нутгийн төсөвт орсон татвар, төлбөр, хураамж, бусад орлогын хэмжээг аймгийн <a href="http://Dornogovi.gov.mn">Dornogovi.gov.mn</a> цахим хуудсанд байршуулж, олон нийтэд мэдээлсэн. Татвар төлөгчдөд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг байнга хийж хэвшсэн ба татвар төлөгчдийн өдрүүдийг 2010 оны 5 дугаар сард 7 хоног зохион байгуулж, 6950 татвар төлөгчийг хамруулан гарын авлага, заавар, зөвлөмж өгч ажиллалаа.	100%
3.7	Үйлчилгээний хөлс болон төлбөр, хураамж авах хэлбэрийг боловсронгуй болгох чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байх.	Татвар, төлбөр, хураамж, бусад орлогыг татвар төлөгчдөөс бэлэн бус хэлбэрээр хураан орон нутгийн төсөвт төвлөрүүлдэг. Иргэд, татвар төлөгчдөд чирэгдэлгүй үйлчлэх зорилгоор аймгийн Нэг цонхны үйлчилгээний төвд татварын улсын байцаагчийг байнга ажиллуулж, татвар, төлбөр, хураамж, бусад орлогыг хураах ажлыг зохион байгуулж байна. Бүх төрлийн татварын тайланг цахим хуудсаар илгээх боломжийг татвар төлөгчдөд бүрдүүлэн ажилласан.	100%
<b>Дөрөв. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдал</b>			

4.1	Ил тод, шударга, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчимд суурилсан худалдан авах ажиллагааны бодлого баримтлан, байгууллагын дотор мөрдөх журмыг батлан, энэ талаар олон нийтэд мэдээлсэн байх;	Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 143-р тогтоол, аймгийн Засаг даргын 2010 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/408 дугаар захирамжаар Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталж, уг дүрмээр Төрийн захиргааны албан хаагчид байгууллагын өмнө тавигдсан зорилго, зорилт /төрийн бодлого/-г хэрэгжүүлэх, стратеги төлөвлөлт гаргах, бодлогын удирдамжаар хангах, төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх үүргээ биелүүлэх, үйл ажиллагаандаа баримтлах зарчим, хэм хэмжээг тодорхой зааж өгсөн.	100%
4.2	Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам болон тендерийн урилгыг хуульд заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, цахим хуудас /www.e-procurement.mn/-т байршуулан, тогтмол шинэчилж байх;	Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2010 онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний жилийн эцсийн тайланд тусгагдсан нийт 22 бараа, ажлууд /50 сая төгрөгнөөс дээш ажил, 30-сая төгрөгнөөс дээш бараа/-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг нээлттэйгээр Зууны мэдээ болон Өдрийн сонин, Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд урилгыг нийтэлж, үр дүнг тухай бүрт нь мэдээлсэн.	100%
4.3	Үнэлгээний хороонд тухайн салбарын 2-оос доошгүй төрийн бус байгууллагын төлөөлөл /ашиг сонирхлын зөрчилгүй болохыг мэдэгдсэн бол/-ийг оролцуулсан байх;	Улсын төсвийн 2031,6 сая төгрөг, орон нутгийн төсвийн 1057,8 сая төгрөг, байгууллагын урсгал төсөвт тусгагдсан 197,7 сая, нийт 3287,1 сая төгрөгийн батлагдсан хөрөнгөөр 2010 онд нийт 41 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд аймгийн Засаг даргын захирамжаар үнэлгээний хороог байгуулан, бүрэлдэхүүнд нь төрийн бус байгууллага, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулан, худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.	100%
4.4	Тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт болон гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу ил тод мэдээлсэн байх;	Тухайн бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах шаардлага нөхцлийг тендерийн баримт бичигт тусган өгч, шаардлагатай мэдээллээр тендерт оролцогчдыг хангаж ажилласан.	100%
4.5	Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаархи товч мэдээллийг байгууллагын цахим хуудаст байршуулан, шалгарсан болон шалгарч чадаагүй шалтгаан нөхцөл, хуулийн үндэслэлийн талаар тодорхой танилцуулсан байх;	Тендерт оролцож шалгарсан болон шалгараагүй оролцогчид захиалагч байгууллагын даргын албан бичгээр шалтгаан үндэслэлийг тодорхой тусгаж мэдэгдлийг хүргүүлж ажилласан. Мөн Монгол Улсын Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудсанд шалгарсан шалгараагүй компаниудын талаарх мэдээллийг тодорхой тусган үр дүнг тухай бүрт нь нийтэд мэдээлсэн.	100%

4.6	Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвшсэн байх;	Худалдан авсан бараа, ажил үйлчилгээний тайланг аймгийн веб сайтад тухай бүрт нь тавьж мэдээлсэн. Мөн тайланг салбар яамд болон Сангийн яаманд сар болон улиралд хүргүүлж ажилласан.	100%
4.7	Тендер шалгаруулах явцад илэрсэн зөрчлийн талаар тухай бүр холбогдох байгууллагад мэдээлсэн байх;	Тендер шалгаруулалтын явцад аливаа зөрчил гараагүй болно.	100%
4.8	Худалдан авах ажиллагааны чиглэлээр холбогдох албан хаагчдыг мэргэшүүлсэн байх;	2010 оны 3-р сард Худалдан авах ажиллагааны хөгжлийн төв ТББ-ын сургагч багшийг аймагтаа урьж ирүүлэн бүх сумд, агентлаг төсөвт байгууллагын 50 албан хаагчдыг сургалтанд хамруулан АЗ сертификатын эрх авах шалгалтыг сургалтанд оролцогчдоос авснаар Сангийн яаманд шалгалтын дүнг гаргах үед нийт 28 албан хаагч шалгалтанд тэнцэж худалдан авах ажиллагааны мэргэжсэн ажилтанг гэрчлэх сертификат аваад байна. Мөн Худалдан авах ажиллагааны орон нутгийн сургагч багшийн зүгээс 2011 оны 1-р сарын 28-ны өдөр орон нутгийн тендерт оролцогч 10 гаруй бизнес эрхлэгчдэд зориулан худалдан авах ажиллагаанд оролцох чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор сургалтыг зохион байгуулсан.	100%
4.9	Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт, шалгалтын дүнг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан, түүнтэй танилцах боломжийг бүрдүүлсэн байх;	Аудитын газраас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2010 онд худалдан авсан бараа, ажил үйлчилгээний баримтыг хянаж шалгах ажил явагдаж байна.	100%
4.10	Худалдан авах ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо, тэдгээрийн товч агуулга, шийдвэрлэсэн байдлыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрлуулан мэдээлсэн байх.	Алтанширээ, Дэлгэрэх сумдын эмнэлэгт нарны зайгаар ажилладаг зөөврийн лаборатори нийлүүлэх ажил, бэлчээр усжуулах зорилгоор гүний өрмийн худгуудад салхин сэнсэн шахуурга суулгах ажлын тендерийг орон нутагт 2 ч удаа зарласнаар УИХ-ын гишүүн Я. Батсуурийн санаачлан 2010 оны улсын төсөвт батлуулсан уг хөрөнгөд тавигдсан шаардлагыг тендерт оролцогч компаниуд хангахгүй шалтгаанаар хүчингүй болж байсан. Алтанширээ, Дэлгэрэх сумдын эмнэлэгт нарны зайгаар ажилладаг зөөврийн лаборатори нийлүүлэхтэй холбогдуулан тендерт оролцогч “Тунамал мед” ХХК-аас Сангийн яаманд гомдол гаргасны дагуу тендерт оролцогч компанийн талд гомдол шийдэгдснээр дахин нээлттэй тендер	100%

	зарлах хугацаанд УИХ-ын гишүүн Я.Батсуурийн тавьсан шаардлагын дагуу түр зогсоосон байсан. Харин гишүүний саналаар хөрөнгийн захиалагчийн эрх Эрүүл мэндийн яаманд шилжсэнээр тус яаманд худалдан авах ажиллагааг зохион байгуулан, төслийг хэрэгжүүлсэн.	
ХЭРЭГЖИЛТИЙН ДУНДАЖ ХУВЬ		100%
ҮНЭЛГЭЭНИЙ ОНОО		5 оноо

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР